



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 11 сарын 2 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6, Испани улсын Ровира И Виржили Их сургуулийн тодорхойлолт болон нэхэмжлэх, Сургалтын төрийн сангийн 2004 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 163 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Испани улсын Ровира И Виржили Их сургуулийн докторантурт компьютерийн ухааны чиглэлээр суралцаж буй Ишдорж овогтой Цэрэн-Онолтын суралцах хугацааг дахин сунгах нөхцөлгүйгээр 2 жилээр сунгаж, Сургалтын төрийн сангаас сургалтын зардлын зээлийг олгосугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчийн гэрээг сунгаж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН